

## ГАРЧИГ

|  |    |
|--|----|
| 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ .....   | 3  |
| 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН<br>ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА .....            | 8  |
| 3.1. Агаар орчинд үүсэх сөрөг нөлөөллийг бууруулахад хийгдсэн ажил:.....   | 11 |
| 3.2. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх ажил...                                     | 14 |
| 3.3. Хөрс, ургамал болон амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хамгаалахад<br>хийгдсэн ажлууд.....             | 17 |
| 3.4. Нөхөн сэргээлт, тэр бум мод, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний<br>төлөвлөгөөний биелэлт.....                   | 20 |
| 3.5. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ.....  | 23 |
| 3.6. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт.....  | 26 |
| 3.7. Химийн бодис эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт.....  | 29 |
| 3.9. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион<br>байгуулалтын төлөвлөгөөний биелэлт ..... | 32 |
| ДҮГНЭЛТ .....  | 40 |


## 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

### Төслийн товч танилцуулга

Морьт уулын хайлуур жоншны орд нь засаг захиргааны хувьд Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутагт орших бөгөөд Улаанбаатар хотоос урд зүгт 350 км, Дундговь аймгийн төв Мандалговь хотоос зүүн урд зүгт 75 км, Гурвансайхан сумын төвөөс баруун урд зүгт 18 км зайтай. Талбай нь номенклатурын хувьд L-48-94 планшетэд байрладаг.

Хүснэгт 1. Талбайн солбицол

|   |                 |                |
|---|-----------------|----------------|
| 1 | 106° 56' 20.51" | 45° 23' 1.58"  |
| 2 | 106° 56' 23.01" | 45° 22' 59.46" |
| 3 | 106° 56' 31.45" | 45° 23' 1.57"  |
| 4 | 106° 57' 19"    | 45° 23' 1.57"  |
| 5 | 106° 57' 19"    | 45° 22' 18.5"  |
| 6 | 106° 55' 8.4"   | 45° 22' 18.5"  |
| 7 | 106° 55' 8.4"   | 45° 23' 1.58"  |



Зураг 1. Талбайн байршлын тойм зураг

ДУНГОВЬ АЙМГИЙН ГУРВАНСАЙХАН СУМЫН НУТАГТ ОРШИХ МУ-022163 ТООТ  
АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙ БҮХИЙ “МОРЪТ УУЛ”-ЫН ХАЙЛУУР  
ЖОНШНЫ ОРДЫН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН





**Зураг 2. Уурхайн ерөнхий байдал**

“Морьт уул”-ын хайлуур жоншны ордын нөөцийн тооцоог хайгуулын 6-н шугамд өрөмдсөн 518 т.м бүхий 10 цооног, 1749 м<sup>3</sup> суваг нэвтрэлт, 169 ш төрөл бүрийн сорьцын лабораторийн шинжилгээний үр дүн, холбогдох судалгааны үр дүнгээр тооцсон болно. Морьт уулын хэсгийн хэмжээнд бодитой (В) зэрэглэлээр 52.05%-ийн СаF<sub>2</sub>-ийн агуулга бүхий 70.55 мян.тн хүдэрт 36.72 мян. тн флюоритын нөөц, боломжтой С зэргээр 51.18%-ийн СаF<sub>2</sub>-ийн агуулга бүхий 49.63 мян.тн хүдэрт 25.4 мян.тн флюоритын нөөцтэй. Нийт бодитой, боломжтой (В+С) зэрэглэлээр 51.69%-ийн СаF<sub>2</sub>-ийн агуулга бүхий 120.18 мян.тн хүдэрт 62.12 мян.тн флюоритын нөөцтэй гэж тогтоосон.

Анх АМГ-ын Кадастрын хэлтсийн даргын 2016 оны 1-р сарын 7-ны өдрийн 21 тоот шийдвэрээр “Очир Ундраа” ХХК-д Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутагт орших “Цагаан дэл” нэртэй XV-020438 тоот 8923.96 га талбай бүхий хайгуулын тусгай зөвшөөрлийг олгосон. Уг тусгай зөвшөөрлийг АМГТГ-ын Геологи, Уул уурхайн кадастрын хэлтсийн даргын 2021 оны 07-р сарын 09-ний өдрийн 258 тоот шийдвэрээр XV-020438 тоот хайгуулын тусгай зөвшөөрлийг “Очир Ундраа” ХХК-аас “Очир Мандал Хайрхан” ХХК руу бүхэлд нь шилжүүлсэн байдаг.

### **Ордын уул техникийн нөхцөл**

Морьт уулын хайлуур жоншны орд нь 3 хүдрийн биетээс тогтох ба хүдрийн биетүүд нь харьцангуй жижиг, хүдрийн агуулга бага зэргийг харгалзан үзээд III бүлгийн ордод хамруулсан.

Хүдрийн биетийн хувьд өргөргийн дагуу чиглэлтэй хойшоо 60-80°-ын өнцгөөр унасан, судал, линз хэлбэртэй, суналын дагуу 100-130 м урттай, 2.0-9.3 м зузаан үндсэн гурван хүдрийн биетээс бүрдэнэ. Ордын хэмжээнд бодитой (В) зэрэглэлээр 52.05%-ийн СаF<sub>2</sub>-ийн агуулга бүхий 70.55 мян.тн хүдэрт 36.72 мян. тн флюоритын нөөц, боломжтой С зэргээр 51.18%-ийн СаF<sub>2</sub>-ийн агуулга бүхий 49.63 мян.тн хүдэрт 25.4 мян.тн флюоритын нөөцтэй. Нийт бодитой, боломжтой (В+С) зэрэглэлээр 51.69%-ийн СаF<sub>2</sub>-ийн агуулга бүхий 120.18 мян.тн хүдэрт 62.12 мян.тн флюоритын нөөцтэй гэж тогтоосон.

- Хүдрийн эзлэхүүн жин /дундаж/ - 2.73 тн/м<sup>3</sup>

- Хүдрийн дундаж агуулга – 34.65%

- Чулуулгийн шахалтын бат бөх – 39.3-115.5 мПа

- Хөрсний чулуулгийн бат бэхийн коэффициент (М.М.Продтъяковын ангилал)

f =8-14 байна.

### **Уурхайн ашиглалтын технологи**

Оновчлолын тооцоолол, мөнгөн урсгалын шинжилгээний үр дүнгээр уурхайн эцсийн хүрээ хязгаар RF=2 үед орлогын хүчин зүйл эерэг байгаа учир ордын бүх нөөцийг ашиглах хувилбарыг сонгож байна.

Ордыг ашиглах технологи нь уурхайн хөрс хуулалт, хүдэр олборлолтын болон туслах ажлуудыг иж бүрнээр нь аюулгүй, эдийн засгийн үр ашигтай, ашигт малтмалын нөөцийг зохистой ашиглахын зэрэгцээ төлөвлөгөөт бүтээлийг хангах ёстой. Ордын геологи болон уул техникийн нөхцөл талаас гадаад овоолго бүхий тээвэртэй ашиглалтын системийг хэрэглэх нь хамгийн зохистой шийдэл болох юм. Иймээс хөрсийг гадаад овоолгод хураах тээвэртэй ашиглалтын систем бүхий технологийг сонгон авсан. Уулын ажлын ерөнхий чиглэл дээрээс доош чиглэсэн байна.

Уурхайн үндсэн болон туслах тоног төхөөрөмжүүдийг захиалагч компанийн техникийн даалгаварт тусгасан саналын дагуу авч тооцсон. Өрөмдлөгийн ажилд Atlas Copco DM25 маркийн өрмийн машин, ухаж-ачих үндсэн тоног төхөөрөмжөөр 1.1 м3 утгуурын багтаамжтай Hyundai-NX180L маркийн гидравлик экскаватор, уулын цулыг тээвэрлэхэд 20 тонны даацтай Howo маркийн автосамосвал тус тус хэрэглэнэ. Экскаваторын ашигтай ажиллагааг хангахын тулд тэслэгдсэн уулын цулын мөргөцгийн хэлбэрийг оновчтой байлгах, зам талбай цэвэрлэх, овоолго дээрх хөрс түрэх зэрэг туслах ажлуудад Shantui-SD13 төрлийн бульдозер, CAT-160K грейдер зэргийг ашиглахаар төсөлд тусгав.

### **Ил уурхайн процесс**

Ил уурхайн процесс нь уурхайн хөрс хуулалт, хүдэр олборлолт, овоолго байгуулах болон туслах ажлуудыг иж бүрнээр нь аюул осолгүй, эдийн засгийн үр ашигтай явуулах, зорилгод бүтээмжийг хангах ёстой.

Ил уурхайд дараах процессууд явагдана: Үүнд

- Шимт хөрс хуулалт
- Өрөмдлөг, тэсэлгээ
- Ухаж ачих
- Тээвэрлэх

## 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

**Байгаль, цаг уур:** Дундговь аймгийн агаарын температур ОЖД-аар 1,1-4,7 градусын хооронд хэлбэлздэг байна. Хамгийн хүйтэн 1 дүгээр сард агаарын дундаж температур -16,7 градусаас -19,6 градус байхад агаарын үнэмлэхүй хамгийн бага -39,7 градус 1981 онд Сайхан-овоо өртөөнд ажиглагдсан байдаг. Хамгийн дулаан 7 дугаар сард агаарын температур 19,9 градусаас 22,3 градус байхад агаарын үнэмлэхүй их температур 41,3 градус Гурвансайхан өртөөн дээр 1999 онд ажиглагдсан байдаг байна. Дундговь аймгийн агаарын дундаж температур 2,6 градусаар дулаарсан.

**Ургамлын бүрхэвч:** Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутагт орших төслийн талбай нь Монгол орны ургамал газарзүйн тойргоор Дундад халхын хээрийн тойрогт хамаарагддаг (Өлзийхутаг Н.). Энэ тойрогт 793 зүйл ургамалтай бөгөөд зөвхөн энэ тойрогт ургадаг 1 зүйл (*Paraver rubro-aurantiacum*)ийн ургамалтай. Дундад Халхын тойргийн үндсэн төрхийг үзүүлэх зүйлүүд: Жижигнавчит харгана (*Caragana microphylla*), Япон хайлас (*Ulmus pumila*), Бариулт бүйлэс (*Amygdalus pedunculata*), Дэрэвгэр тарна (*Polygonum divaricatum*, Дорнодын хамхуул (*Corispermum orientale*), Дэрвээн цульхир (*Agriophyllum pungens*), Монгол хамхуул (*Corispermum mongolicum*), Услиг мананхамхаг (*Bassia dasyphylla*), Козловын сүүт-өвс (*Euphorbia kozlovii*), Сибирь шорной (*Atriplex sibirica*), Эрлийз лууль (*Chenopodium hybridum*), Клеменцийн ортууз (*Oxytropis klementzii*), Хангайн шарилж (*Artemisia changaica*), Толгодын багваахай (*Taraxacum collinum*) зэрэг болно.

**Ан амьтан:** Гурвансайхан сумын нутаг нь байгалийн бүс бүслүүрийн хувьд хуурай хээр, цөлжүү хээрт хамаарна. Тиймээс говь, цөлийн амьтад зонхилон байршина. Амьтны тархалт, тоо хэмжээний хувьд дунд зэрэг. Туурайтнаас намартаа цагаан зээр нүүдэллэн ирдэг. Жигүүртнээс элээ, хэрээ, тас, харцага, ногтруу, шаазгай, шар шувуу, ууль, тагтаа, хэвлээр явагчдаас могой, гүрвэл мэрэгчдээс үлийн цагаан, шар сүүлт, алаг даага, махчин амьтдаас чоно, үнэг, хярс, шавж идэштнээс зараа зэрэг тохиолдоно.

**Хөрсөн бүрхэвч:** Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутагт байрлах энэхүү уурхай нь Хөрс-Газарзүйн мужлалаар хөрс био-уур амьсгалын Хангайн их мужийн Өргөргийн бүсшилтэй нутаг Бүрд-Баянцагааны 3-р тойрогт хамрагдана. Газрын гадаргын хэлбэр дүрсийн хувьд нам өндөртэй ухаа толгод тэдгээрийг хоорондох хөндий болон хэрчигдлүүд ажиглагдана. Судалгаанд хамрагдсан талбайд толгодын хүрэн хөрс зонхилон тархсан байна. Төслийн талбайн хөрсөн бүрхэвч антропоген болон техноген нөлөөлөлд өртөөгүй байгаа бөгөөд зөвхөн байгалийн гаралтай хөрс болон усаар элэгдсэн хэлбэрүүд ажиглагдаж байна.

**Газар зүй:** Говийн их мужийн, умард говийн ухаа толгодлог талын дэд мужид хамаарна. Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутгийн баруун урд хэсэгт хээр ба говийн их мужийн шилжилтийн заагийн цав толгодлог, ухаа гүвээт гэсэн хоёр төрлийн гадарга зонхилдог.

### Дундговь аймаг

Дундговь аймаг нь Монгол улсын нутгийн төв хэсэгт 74.69 мянган хавтгай дөрвөлжин км нутаг дэвсгэртэй бөгөөд урд талаараа Өмнөговь, баруун талаараа Өвөрхангай, хойд талаараа Төв, зүүн хойд талаараа Говьсүмбэр, зүүн урд талаараа Дорноговь аймгуудтай тус тус хиллэн оршино. Аймгийн төв Мандалговь хот нь Улаанбаатар хотоос 270 км зайтай

бөгөөд Дундговь аймаг нь 15 сум, 68 багтай. Аймаг нь 47,274 хүн амтай ба 14 мянган айл өрхтэй. Нийт хүн амын 50.3 хувь эрэгтэйчүүд, 49.7 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.

#### **Гурвансайхан сум**

Гурвансайхан сум нь 541.64 мян.га талбай бүхий газар нутагтай. Газарзүйн хувьд говийн бүсэд багтдаг, сумын хамгийн хойд талын цэг Баянзүрх уул, урд цэг Хэрээ шарга овоо, Зайрмагтайн худаг, зүүн захын цэг Хамар цагаан жаргалан уул, баруун захын цэг Хөөвөрийн худаг хүрдэг. Тус сум нийт 2.1 мянган хүн амтай үүний 51.0% эрэгтэйчүүд, 49.0% эмэгтэйчүүд байна.

### **2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт, биелэлт**

2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа байгаль орчин, ногоон хөгжлийн яамны сайдын 2019 оны 10 дугаар сарын 29 –ны өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан аргачлалын дагуу боловсруулан батлуулсан.

2025 онд 24.32 мян.тн хүдэр олборлон 16.41 мян.тн хайлуур жонш олборлон баяжуулахаар төлөвлөсөн байна.

### **Уурхайн нөхөн сэргээлт**

Тус хайлуур жоншны орд нь ашиглалтын үйл ажиллагаатай зэрэгцэн нөхөн сэргээлт хийх боломжгүй бөгөөд 2025 онд техникийн болон биологийн нөхөн сэргээлт төлөвлөөгүй.

### **Шимт хөрс хуулах ажил**

- Уурхайн ашиглалтын явцад эвдрэлд өртөх нийт талбайн шимт хөрсийг хуулан, шимт хөрсний овоолго үүсгэж хураана. Энэ нь ашиглалт дууссаны дараа биологийн нөхөн сэргээлт хийх боломжийг хангана. Шимт хөрсийг 30 см зузаантай байхаар тооцож хуулна.
- Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт /MNS5916:2008/ стандартыг дагаж мөрдөнө. Шимт хөрсний овоолгын өндрийг 5-10 м-ээс ихгүйгээр хийх ба 2 жил ба түүнээс дээш удаан хугацаагаар хадгалагдах тохиолдолд овоолгын хөрсийг эвдрэлээс хамгаалах, хөрсний бичил биетийн амьдралыг тэтгэх үүднээс гадаргыг нь ургамалжуулна.

### **Хөрсний овоолгын хэлбэржүүлэлт**

- Ордын уул геологи, уул техникийн нөхцөлөөс хамааруулан гадаад болон дотоод овоолготой ашиглалтын системээр олборлолтын ажлыг явуулна. Хөрсний овоолго нь 20 метр өндөр, тээврийн зурвасын өргөн 10 метр, доголын налуу 35 градус ба ярусын өндөр 10 метр, аюулгүйн тавцангийн өргөн 5 метр, овоолгын ерөнхий хажуугийн өнцөг 30 градус байна.

Хөрсний овоолгын хэлбэржүүлэлт болон уурхайн туслах ажлуудыг бульдозерын тусламжтай гүйцэтгэнэ. Уурхайн хөрсний гадаад болон дотоод овоолгын хажууг 18 градус хүртэл түрж налууулна.


### 3. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

#### 3.1. Агаар орчинд үүсэх сөрөг нөлөөллийг бууруулахад хийгдсэн ажил:

Үйл ажиллагаа явагдахаас өөр газруудад машин, техникүүдийг замбараагүй явуулахгүй байх зааварчилгааг тогтмол өгч мөрдүүлж ажилласан ба 2025 оны БОМТ-д тусгагдсан дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

#### Хүснэгт 2. Агаар орчинд үүсэх сөрөг нөлөөллийг бууруулахад хийгдсэн ажил

| Д.д | Төлөвлөгөө   | Биелэлт, зарцуулсан зардал мян.төг  |
|-----|--|---|
| 1   | Уурхайн дотоод замыг услах,  | Уурхайн олборлолтын үйл ажиллагаа явагдаж байх үед усалгааг тогтмол хийж байсан. Зардал нь усны зардалд орсон болно.  |
| 2   | Уурхайд ажиллаж байгаа машин техникийн кабин доторх агааржуулах төхөөрөмж, хэрэгслийн бүрэн бүтэн байдал, хаалга, цонхны чигжээс, хамгаалалтын үзлэгийг тогтмол хийж, зөрчил илэрсэн тохиолдолд шуурхай арга хэмжээ авч бүхээгт тоос орохгүй болгох арга хэмжээ авч байх | 250 мот/цаг тутамд тээврийн хэрэгслүүдийн масло, маслын шүүр, агаар болон, түлшний шүүрүүдийг байнга сольж байсан. Үйл ажиллагааны зардалд орсон. Уурхайд ажиллаж байгаа машин техникүүдэд агааржуулах төхөөрөмж суурилуулсан бөгөөд хаалга цонхны битүүмж бүрэн бүтэн байдлын үзлэгийг хийж зөрчил илэрсэн тохиолдолд холбогдох арга хэмжээг авч ажиллаж байсан. |
| 3   | Мөн агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг тогтоох, бууруулахын тулд хяналт шинжилгээг тогтмол хэрэгжүүлнэ.   | Хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгасан агаарын шинжилгээг 8-р сард “Ногоон эко Мандала” ХХК –р хийлгэсэн. Зардал нь орчны хяналт шинжилгээний зардалд багтсан   |
| 4   | Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн дагуу уурхайд ашиглагдаж байгаа тоног төхөөрөмжүүдийнхээ төлбөрийг төлнө. Уулын ажилд хамрагдах тээврийн хэрэгслүүд байна.   | Агаарын бохирдлын төлбөр төлсөн   |
|     | Нийт   | -мян төг  |



Зураг 1. Агаарын шинжилгээ хийлгэж байх үеийн зураг



**Зураг 2. Агааржуулах систем суурилуулсан үеийн зураг**



**Зураг 3. Усалгаа хийж байх үеийн зураг**

### 3.2. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх ажил

#### Ус, усан орчинд үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах:

2025 оны 8-р сарын 18-ны өдөр Дундговь аймгийн Гурвансайхан сумын засаг даргатай гэрээ байгуулсан.


#### Хүснэгт 3. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хамгаалахад хийгдсэн ажлууд

| Д.д | Төлөвлөгөө  | Хариуцсан эзэн    | Биелэлт, зарцуулсан зардал мян.төг  |
|-----|---|-------------------|---|
| 1   | Ус ашиглах гэрээгээ байгуулан төлбөрөө төлнө            | Компанийн захирал | Ус ашиглах гэрээг байгуулсан. Гэрээний дагуу ус ашигласан төлбөр 1462.9 мян.төг төлсөн. Гэрээг хавсаргав                        |
| 2   | Худагт тоолуур тавьж баталгаажуулах                     | Уурхайн дарга     | Худагт тоолуур тавьж баталгаажуулсан.   |
| 3   | Хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу шинжилгээ хийлгэх |                   | Усан орчны хяналт шинжилгээг 8-р сард “Ногоон эко Мандала” ХХК-р хийлгэсэн. Зардал нь орчны хяналт шинжилгээний зардалд багтсан |
|     | Нийт зардал   |                   | 1462.9 мян.төг  |



Зураг 4. Усны дээж авч байх үеийн зураг




**СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР**

**УСНЫ ТООЛУУРЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГЭРЧИЛГЭЭ**  
 № ЭУ ..... 224306.


.....-д  
 (хэрэглэгчийн нэр)

ашиглаж байгаа ..... 1х6С ..... загварын ..... 6,0 м³/ц  
 хэмжих хязгаартай, 1,22 мм-ийн голчтой № ..... 2.02200020 .....-ын  
 халуун, хүйтэн усны тоолуурыг № ..... 019 ..... лацаар битүүмжилж  
 (доогуур зурах)

..... 2027 оны ..... 02 -р сарын ..... 25.. -ны өдөр хүртэл улсын  
 баталгаажуулалтын гэрчилгээ олгов.

Шалгалтын дараах заалт: ..... 00000 м³

Лабораторийн тэмдэг .....  
 2025 оны ..... 02 -р сарын 25.. -ны өдөр

  
 Улсын шалзагчдын  
 гарын үсэг, тэмдэг

**Зураг 5. Худагт тоолуур тавьж байх үеийн зураг**

**3.3. Хөрс, ургамал болон амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хамгаалахад хийгдсэн ажлууд**

**Хүснэгт 4. Газар болон хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад хийгдсэн ажлууд**

| Д.д | Төлөвлөгөө  | Хариуцсан эзэн    | Биелэлт, зарцуулсан зардал мян.төг  |
|-----|---|-------------------|---|
| 1   | Газар эзэмших гэрээгээ орон нутагтай байгуулан төлбөрөө төлөх.  | Компанийн захирал | Газар эзэмших гэрээгээ байгуулж 2025 онд нийт 17800.0 мян.төг төлсөн.   |
| 2   | Засварын газар, зогсоолын талбайг цементээр хучих засварын газраас өөр газарт тос масло асгарсан тохиолдолд асгарсан хэсгийг элс асгаж саармагжуулан бохирдсон хөрсийг авч хог хаягдал руу ачуулна. | Уурхайн дарга     | Шатах тослох материалын 400 орчим литр хог хаягдлыг Чойр-т байрлах өөрийн засварын газарлуу зөөвөрлөх арга хэмжээ авч ажилласан. Уурхайн үйл ажиллагаа 6-р сараас зогссон бөгөөд цаашид уурхайн кемпийг нүүлгэх шаардлагатай тул засварын талбайг цементээр хучих ажил хийгдээгүй болно |
| 3   | Шимт хөрсний нөөц бий болгох стандартын дагуу овоолж, хадгалах  |                   | Шимт хөрсийг MNS 5916:2008 стандартын дагуу, хуулж хадгалсан.   |
|     | Нийт зардал   |                   | 17800.0 мян.төг   |



**Зураг 6. Шатах тослох материалын хог хаягдлыг Чойр-луу ачиж байх үеийн зураг**



Зураг 7. Шатах тослох материалын хог хаягдлыг Чойр-луу буулгасан байдал



Зураг 8. Уурхайн шимт хөрс/2025 оны 8-р сар/

**Хүснэгт 5. Ургамал болон амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хамгаалахад хийгдсэн ажлууд**

| Д.д | Төлөвлөгөө  | Хариуцсан эзэн    | Биелэлт, зарцуулсан зардал мян.төг   |
|-----|---|-------------------|--|
| 1   | Олон салаа зам гаргахгүй, нэгдсэн нэг маршрутаар зорчих, зам талбайг засах сайжруулах, тэмдэгжүүлэх | Уурхайн дарга     | Тусгай зөвшөөрлийн талбай болон орон нутагт тогтсон маршрутаар зорчсон бөгөөд гарц таних тэмдэг байршуулсан                    |
| 2   | Орд орчмын ургамлын бүрхэц, зүйлийн бүрдлийн судалгаа   | Компанийн захирал | Орд орчмын хяналт шинжилгээний ажлыг 8-р сард хийж гүйцэтгэсэн бөгөөд зардал нь хяналт шинжилгээ, мониторингийн зардалд орсон. |
|     | <b>Нийт</b>   |                   | <b>500.0</b>   |



**Зураг 9. Уурхайн шаардлагатай газруудад тэмдэг тэмдэглэгээ байршуулсан байдал**

**3.4. Нөхөн сэргээлт, тэр бум мод, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт**

Нөхөн сэргээлтийн ажлын техникийн үе шатанд орд газрыг ашиглаж дууссаны дараа хөрсний овоолгыг хэвгийжүүлж, ухаж эвдэрсэн боломжтой газруудад дүүргэлт хийх, хэлбэршүүлэх, талбайг засаж тэгшлэх, бэлтгэсэн талбайг биологийн нөхөн сэргээлт хийхэд зориулж шимт хөрсөөр хучих зэрэг үйл ажиллагаа хамаарна. Иймд 2025 онд техникийн болон биологийн нөхөн сэргээлт төлөвлөөгүй.

**Хүснэгт 6. Тэр бум модны төлөвлөгөө, биелэлт**

| Д.д | Төлөвлөгөө  | Биелэлт, зарцуулсан зардал мян.төг  |
|-----|---|---|
| 1   | 2025 онд Тэр бум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд сум орон нутгийн саналын дагуу мод тарина | Гурвансайхан сумын нутагт зүүн урд хэсэгт байрлах сумын цэцэрлэгт хүрээлэнд мод тарих ажилд хамтран ажилласан бөгөөд 300 м хамгаалалтын бэлчээрийн тор, 100 ш мод тарималжуулав |
|     | Нийт зардал   | 1575.0  |



Зураг 10. Мод тарьж байх үеийн зураг



ДУНДГОВЬ АЙМАГ  
ГУРВАНСАЙХАН СУМЫН  
ЗАСАГ ДАРГА

Төвийн 4-401 тоот, 5 дугаар баг, Гурвансайхан сум,  
Дундговь аймаг, 48060 Утас: 7059 6407  
Цахим шуудан: info@gurvansaikhan.gov.mn,  
Цахим хуудас: www.gurvansaikhan.gov.mn

2025.12.11 № 1/351  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ДУНДГОВЬ АЙМГИЙН  
БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗАРТ

Дундговь аймгийн Гурвансайхан сумын Дэрсэнэ-Ус багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг “Морьт уул” нэртэй MV-022163 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Очир мандал хайрхан” ХХК нь байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөний дагуу “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Ногоон Дундговь” төслийн хүрээнд, засмал зам дагуу 100 ширхэг хайлаас тарьж, орон нутгийн саналыг дагуу сумын цэвэрлэх байгууламжийг ногооруулах хашаажуулахад 300 метр бэлчээрийн торыг өгч хамтран ажилласан болно.



Б.ЭНХТУЯА

Desktop (2025он тоот А5)

**Зураг 11. Сумын тодорхойлолт**

### 3.5. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ

“Очир мандал хайрхан” ХХК нь 2025 онд талбайгаас зүүн зүгт 14 км-т байрлах Их газрын чулуу Байгалийн цогцолборт газартай хамтран тус тусгай хамгаалалттай газрын төлөвлөгөөт ажилд хөрөнгө оруулан хамтран ажиллахаар төлөвлөсөн бөгөөд 2022 оноос тус газартай хамтран ажиллаж байна.

#### Хүснэгт 7. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний биелэлт

| Д.д | Төлөвлөгөө   | Биелэлт, зарцуулсан зардал мян.төг  |
|-----|--|---|
| 1   | 2025 онд Их газрын чулуу улсын тусгай хамгаалалттай газарт зэрлэг амьтдад зориулсан байршил тогтоогч суурилуулах | 2025 оны 4-р сард Их газрын чулуу байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаатай хийсэн хамтын ажиллагааны гэрээний дагуу биотехникийн арга хэмжээ авах ажилд хамтран ажиллав. Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд 200 боодол өвс худалдан авах гэрээ байгуулан өвсний нөөц бүрдүүлсэн. |
|     | Нийт зардал  | 5120.0 мян.төг  |

БАТЛАВ.  
ОЧИР МАНДАЛ ХАЙРХАН  
ЗАХИРАЛ Б. БАТБАЯР



БАТЛАВ.  
ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГААНЫ  
ДАРГА Р.БАТТҮВШИН

### ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

Мандалговь хот

2025.04.14

Нэг талаас Их газрын чулууны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааг төлөөж мэргэжилтэн Д.Жавхлантөгс / цаашид хамтран ажиллагч тал гэх / Нөгөө талаас Очир мандал хайрхан ХХК-ны захирал Б. Батбаяр /цаашид хамтрагч гэх/ бид дараахь нөхцөлөөр энэхүү гэрээг байгуулав.

#### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Энэхүү гэрээний зорилго нь Их газрын чулууны БЦГ-ын хамгаалалтын захиргаанд байгаль хамгаалал, биотехникийн арга хэмжээ явуулахад хамтран ажиллах харилцааг зохицуулахад оршино.

1.2. Талууд хамтран ажиллахдаа хууль ёсны ашиг сонирхолыг хүндэтгэн гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж, үйл ажиллагаандаа хууль дээдлэх зарчмыг баримтлан ажиллана.

#### ХОЁР. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

2.1 Энэхүү гэрээг 2025 оны 04 дүгээр сарын 01 өдрөөс эхлэн 2025 оны 11 дүгээр сарын 30 өдөр хүртэл байгуулав.

#### ГУРАВ. САНХҮҮЖИЛТ

3.1. Гэрээний нийт санхүүжилт 5,120,000/ Таван сая нэг зуун хорин мянган төгрөг /

3.2. Санхүүжилтийг Төрийн сангийн /MN 040090/100080013404 тоот дансанд байршуулах.

#### ДӨРӨВ. ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЭРХ ҮҮРЭГ

4.1.Гэрээгээр олгогдсон санхүүжилтийг зориулалтын дагуу, үр ашигтай зарцуулах.

4.2. Санхүүжилтийг гэрээнд заасан төрийн сангийн дансанд байршуулах

4.3. Гэрээний хэрэгжилтэд хяналт тавих

#### ТАВ. ХАРИУЦЛАГА

5.1. Энэхүү гэрээг зөрчсөн иргэн, хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

5.2. Захиалагч талаас энэхүү гэрээний хэрэгжилтэнд хуульд заасан эрх үүргийн дагуу хяналт тавьж ажиллана.

### Зураг 3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний биелэлт



### 3.6. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

#### Хүснэгт 8. Хог хаягдлыг менежментээр хийгдсэн ажлууд

| Д.д         | Төлөвлөгөө   | Хариуцсан<br>эзэн | Биелэлт, зарцуулсан зардал<br>мян.төг  |
|-------------|--|-------------------|--|
| 1           | Ахуйн хатуу хог хаягдлыг сумын ТҮК-тэй гэрээ байгуулан зөөвөрлөх   | Уурхайн далга     | 2025 онд байгуулсан гэрээний дагуу 1800.0 мян.төгрөг төлсөн. Уурхайд тогтмол 12 хүн ажилладаг бөгөөд сард 180-200 кг орчим хаягдал гэрээний дагуу сумын төвийн нэгдсэн цэгт зөөвөрлөсөн. |
| 2           | Ахуйн хатуу хог хаягдлаа төрөлжүүлэн ялган ангилах хогийн савнуудыг худалдан авч хог хаягдлын төрлийг хогийн савны гадна бичиж байрлуулна. |                   | Ахуйн хатуу хог хаягдлаа төрөлжүүлэн ялган ангилах хогийн савнуудыг худалдан авч хог хаягдлын төрлийг хогийн савны гадна бичиж байрлуулсан.  |
| 3           | Хог хаягдал түр хадгалах талбайг нэвчилт явагдахааргүй, ирмэг хөвөө бүхий цементэн суурьтай болгон тохижуулах                              |                   | Хог хаягдал түр хадгалах талбайг нэвчилт явагдахааргүй, ирмэг хөвөө бүхий цементэн суурьтай болгон тохижуулсан   |
| 4           | Уурхайд ашиглаж буй машинаас гарсан хаягдал тос, маслог зориулалтын цэгт хуримтлуулах, дугуй ламп гэх мэтийг дахивар авах газарт тушаана.  |                   | 10 тээврийн хэрэгслийн 400 л орчим ашигласан тос маслын хаягдлыг Чойрлуу тээвэрлэсэн.  |
| 5           | Сумын төвийн хог хаягдлын цэгийг булшлах, цэвэрлэх   |                   | Төлөвлөсний дагуу сумын төвийг хог хаягдлын цэгийг цэвэрлэсэн.   |
| Нийт зардал |  |                   | <b>1800.0 мян.төгрөг</b>   |



Зураг 4. Хог хаягдлын цэг ангилан ялгасан, суурийг цементэлсэн байдал



**Зураг 12. Сумын төвийн хогийн цэгийг цэвэрлэхээс өмнө**



**Зураг 13. Сумын төвийн хогийн цэгийг цэвэрлэсний дараа**

**3.7.**

**3.7. Химийн бодис эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт**

Тус төсөл нь химийн бодис ашиглаагүй.

**3.8. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт**


**Хүснэгт 9. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт**

| Д.д | Төлөвлөгөө  | Биелэлт, зарцуулсан зардал мян.төг   |
|-----|---|--|
| 1   | Хөдөлмөр эрхлэлтийн явцад гарч болзошгүй осол бэртэл, өвчлөлийн жагсаалт гаргаж түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийн зөвлөмжийг боловсруулж ажилчдын хүртээл болгох | Ажилчдад тогтмол ажилд гарах бүрд ХАБЭА-н инженер зааварчилгаа өгч, дотооддоо сургалт зохион байгуулж ажилласан.                         |
| 2   | Ажлын өдөр эхлэх бүрд зааварчилгаа өгөх   | Ажилчдад тогтмол ажилд гарах бүрд ХАБЭА-н инженер зааварчилгаа өгч ажилласан.  |
| 3   | Ажилтнуудыг эрүүл мэндийн урьдчилсан болон хугацаат үзлэгт хамруулах  | Ажилчдыг Оношмэд эмнэлэгт 2025 оны 2-р сарын 12-ны өдөр урьдчилсан сэргийлэх үзлэгт хамруулсан. Эрүүл мэндийн үзлэгийн гэрээг хавсаргав. |
| 4   | Ажлын байран дээрх осол эрсдэлээс сэргийлж хөдөлмөр хамгааллын багаж хэрэгслээр хангах  | Хөдөлмөр хамгааллын багаж хэрэгслээр хангасан. 1000.0 мян,төгрөг.  |
| 5   | Анхны түргэн тусламжийн багаж, эмээр хангах   | Ажилчдын хотхонд анхан шатны түргэн тусламжийн багаж, эмээр хангаж байршуулсан 300.0мян төг  |
|     | Нийт зардал   | 1300.0 мян.төг   |

ДУНДГОВЬ АЙМГИЙН ГУРВАНСАЙХАН СУМЫН НУТАГТ ОРШИХ MV-022163 ТООТ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙ БҮХИЙ “МОРЪТ УУЛ”-ЫН ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН



Зураг 5. Хөдөлмөр аюулгүй байдлын заавар



Зураг 14. Хөдөлмөр хамгааллын бүртгэл, зааварчилгааны дэвтэр

**ДУНДГОВЬ АЙМГИЙН ГУРВАНСАЙХАН СУМЫН НУТАГТ ОРШИХ MV-022163 ТООТ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙ БҮХИЙ “МОРЪТ УУЛ”-ЫН ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

Очир Мандал Хайрхан ХХК –ийн ажилтан нарт хийгдсэн урьдчилан сэргийлэх үзлэгийн ерөнхий дүгнэлт  
2025.02.19

Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсанаар эрүүл мэндийн байдлаа тодорхойлуулах, улмаар хявдар, чихрийн шижин, даралт ихдэлт, элэгний вирусийн өвчлөл зэрэг халдварт болон халдварт бус өвчин эмгэгүүдийг эрт үед нь илрүүлж эмчлүүлэх, хүндрэхээс сэргийлэх чухал ач холбогдолтой болно.

Очир Мандал Хайрхан ХХК –ийн ажилтан нарт урьдчилан сэргийлэх үзлэгийг “Гурван цохиот” ХХК –ийн “Ультрасаунд” оношилгоо эмчилгээний төвд 2025 оны 02 дугаар сар 13 - наас эхлэн 02 дугаар сарын 18-ний өдрийг дуустал зохион байгуулж гүйцэтгэсэн.

2025 оны 02 дугаар сар 13-18 ны өдрүүдэд Эмэгтэйчүүд , дотор эрхтний ЭХО оношилгоо, дотрын эмчийн үзлэгийн “Ультрасаунд” оношилгоо эмчилгээний төв дээр хийж гүйцэтгэв .

Энэхүү үзлэг шинжилгээнд :

ЭХО /элэг,цус,ноир булчирхай,далүү,бөөр давсаг/ эр-д түрүү булчирхай , эмэгтэйчүүдэд умайн бүтэц, өндгөөч

Зүрхний цахилгаан бичлэг

Дотрын эмчийн үзлэг,шинжилгээний хариунд дүгнэлт өгөх ,зөвлөгөө өгөх

Урьдчилан сэргийлэх хэт авиан шинжилгээнд 26 хүн хамрагдсанаас

- Эрүүл 4
- Жировой гепатоз / Элэгний өөхлөлт / 7
- Бөөрний киста 1
- Кальцинат печени / Элэгний шохойжилт / 2
- Холестиит / Цэсний хүүдийн үрэвсэл / 8
- Камень желчного пузыря / Цэсний хүүдийн чулуу / 4
- Полип желчного пузыря / Цэсний хүүдийн ургацаг / 3
- Бөөрний шохойжилт / 3
- Реактивный панкреатит / Нойр булчирхайн үрэвсэл / 7
- Миома матка 2

- Хронический гепатит / Бөөрний архаг үрэвсэл / 11
- Камень почки 1
- Элэгний С В D вирус 4
- Бусад шалтгаант элэгний үрэвсэл 7
- Сахарный диабет 5
- Хеликобактерийн шалтгаантай ходоодны үрэвсэл 12
- Артерийн даралт ихсэлт 5
- ИБС 3

гэсэн өөрчлөлтүүд тус тус илэрлээ. /Энэхүү тоо хэмжээг давхардсан тоогоор гэж ойлгох хэрэгтэй /

Шинжилгээ болон үзлэгийн хариу дүгнэлт эмнэлгийн мэдээллийн санд хадгалагдан архивлагдах болно.

Цаашид шинжилгээгээр элэгний В вирус илрээгүй ажилчид В вирусийн эсрэг вакцин хамрагдах хэрэгтэй.Энэ вакциныг хийлгэснээр элэгний Д вирусас мөн хамгаалагдана.Тус вакцин нь 3 удаагийн тун хийгдэх бөгөөд харьяа дүүргийн эрүүл мэндийн төв дээр хийдэг болно. Вакцины дараа дархлаа тогтсон эсэхээ лабораторид / anti-HBs – В вирусийн эсрэг эсрэг бие / шалгуулсанаар вакцины үр дүнг хянана.

Ажилчдын ажлын цагийн хэмнэл, ажиллах орчны нөлөө, хувь хүний зохион байгуулалт зэргээс шалтгаалан хоол боловсруулах замын өөрчлөлт болон бөөр нурууны суулт , үрэвсэл их байгаа учир зөв хооллолт, зөв хувцаслалт, ажиллах нөхцөл, амьдралын хэмнэлийн талаар анхаарах хэрэгтэй,

Цаашид нарийн мэргэжлийн эмчид үзүүлж шинжилгээ хийлгэх шаардлагатай

С. Отгонбаатар ,П.Мөнхбаясгалан ,Л. Мөнхболд, А. Нямсүрэн нар

Элэгний В болон С вирустай ажилчид гепатологич эмчийн тогтмол хяналтанд байх шаардлагатай.

Энэхүү үзлэг шинжилгээгээр эмчилгээ хийлгэх , эмчлүүлэх шаардлагатай ажилчид байсан бөгөөд хүн тус бүрт нь байдлыг танилцуулж зөвлөгөө өгсөн

Ультрасаунд эмчилгээ оношлогооны төвийн

эмч : А.Дариймаа

[Darimaa\\_1@yahoo.com](mailto:Darimaa_1@yahoo.com) / 99050649 /

Acti

**Зураг 6. Эмнэлгийн дүгнэлт**

**3.9. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт**

Байгаль орчныг хамгаалах, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар 1 удаа сургалт, сурталчилгааны ажлыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран зохион байгуулсан. Үйл ажиллагаандаа технологийн сахилга батыг чанд баримталж, аваар осолгүй ажиллах талаар байнга анхаарал тавихыг уурхайн дарга хариуцан ажилласан.


**Хүснэгт 10. 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлсэн удирдлага зохион байгуулалтын ажил**


| № | Төлөвлөгөө   | Хэрэгжүүлсэн арга хэмжээ   | Хариуцсан эзэн | Тайлбар, зарцуулсан зардал мян.төг |
|---|--|--|----------------|------------------------------------|
| 1 | Ус ашиглах дүгнэлт гаргуулан, холбогдох газраас ус ашиглах зөвшөөрөл авах  | Ус ашиглах дүгнэлт гаргуулан гэрээний дагуу төлбөрийг төлж ажилласан   | Уурхайн дарга  | Дотоод төлөвлөлтөөр                |
| 2 | Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 101 болон БО-ы ерөнхий үнэлгээний шаардлагын дагуу 2 жил тутамд Байгаль орчны аудит хийлгэх | Ордын аудитын тайланг Сайн тусгал ХХК-иар 2025 оны 5-р сард хийлгэсэн. | Уурхайн дарга  | Дотоод төлөвлөлтөөр                |

|   |  |                                |  |
|---|--|--------------------------------|--|
|   |  |                                |  |
| 3 | Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх | Дотоод журмын дагуу ажилласан. |  |

**Хүснэгт 11. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах хуваарь**

| №           | Төлөвлөгөө  | Хэрэгжүүлсэн арга хэмжээ   |
|-------------|---|--|
| 1           | Уурхайн үйл ажиллагаатай сум орон нутгийн иргэд, ЗДТГ-ын мэргэжилтэн, холбогдох мэргэжилтнүүдийг газар дээр нь танилцуулна. | Уурхайн үйл ажиллагаа 6-р сард зогссон бөгөөд 2026 оны БОМТ-д тусгаж ажиллахаар төлөвлөж байна. Багийн 19 өрхөд үйл ажиллагаагаа танилцуулан өвлийн бэлтгэл ажилд зориулан тусламж үзүүлсэн. |
| 2           | Менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг боловсруулан аймгийн байгаль орчны албанд хүргүүлнэ.                        | БОМТ-ний биелэлтийн тайланг боловсруулсан 11-р сард цахим системд илгээсэн болно.  |
| Нийт зардал |   | -  |

Батлав:  
“Очир мандал хайрхан” ХХК-ийн  
захирал  /Б.Батбаяр/



**“ОЧИР МАНДАЛ ХАЙРХАН” ХХК-ИЙН  
ДОТООД ЖУРАМ**

2022 он

“Очир мандал хайрхан” ХХК  
“Хайлуур жоншны ордыг ил аргаар ашиглах” төсөл  
байгаль орчны аудитын тайлагнийн зөвлөмж, дүгнэлт



**ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСӨЛ  
БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТЫН НЭГДСЭН ДҮН,  
ЗӨВЛӨМЖ, ДҮГНЭЛТ**

Захиалагч: “Очир мандал хайрхан” ХХК  
Гүйцэтгэгч: “Сайн Тусгал” ХХК



2025

Очирмандал хайрхан ххк Өвс тусламж

| №  | Овог нэр                    | Гарын үсэг   | утас     |
|----|-----------------------------|--------------|----------|
| 1  | Б.Ринчинмядаг 2км - 30м     | 2гика        | 95271725 |
| 2  | Н.Шатар 3км - 30м           | Шатар        | 94114210 |
| 3  | Ш.Баянмөнх 3км - 30м        | Ш.Баянмөнх   | 94114220 |
| 4  | Х.Мөнхжаргал 4км - 30м      | Х.Мөнхжаргал | 95541658 |
| 5  | Ж.Түмэнбаяр 5км - 30м       | Ж.Түмэнбаяр  | 96126022 |
| 6  | Г.Адъяа 5км 30м             | Адъяа        | 86491008 |
| 7  | Б.Мөнгөншагай 10км 30м      | Мөнгөншагай  | 51293370 |
| 8  | Д.Өлзийбаатар 10км - 30м    | Өлзийбаатар  | 99955485 |
| 9  | Г.Монхор 10км - 30м         | Монхор       | 59150674 |
| 10 | А.Энхамгалан 12км 30м - 10м | Энх амгалан  | 91267791 |
| 11 | Ө.Доржоо 5км - 30м          | Доржсүрэн    | 85654465 |
| 12 | Д.Отгонтуяа                 |              |          |
| 13 | Х.Манал 30м 3км             | Манал        | 91631229 |
| 14 | Б.Батжаргал 30м 4км         | Батжаргал    | 95185265 |
| 15 | Базаржав 3км 30м            | Базаржав     | 89158724 |
| 16 | Д.Цэцэгсумъяа 5км 30м +     | Цэцэгсумъяа  | 85445558 |
| 17 | Б.БАТБАЯР 30м 13км          | Батбаяр      | 99890584 |
| 18 | Д. Очирнурзв 30м 6км        | Очир         | 80259500 |
| 19 | Манзхбаяр 20м 8км           | Манзхбаяр    | 86907170 |
|    | Нийт үүсвэр 50м             |              |          |
|    | Нийт 586м боодал өвс        |              |          |

Жолооч данс: 5024440416

Н. Очиртуулсан

89681971

### 3.10. Хяналт шинжилгээний ажлын биелэлт

| № | Хяналт шинжилгээний дээж | Хяналт шинжилгээний үзүүлэлт   | Хяналт шинжилгээ явуулсан хугацаа | Хяналт шинжилгээ явуулсан байршил                                    | Хяналт шинжилгээ хийсэн багаж, холбогдох стандарт   |
|---|--------------------------|--|-----------------------------------|--|---|
| 1 | Агаар                    | Агаар орчны бохирдол агаар дахь тоосны агууламж,   | 8 сард                            | Уурхайн хотхон<br>Засварын талбай,<br>Уурхайн карьер,<br>Уурхайн зам | Агаарын тухай хууль, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, Агаарын чанар- хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ MNS 6063: 2010, Агаарын чанар техникийн ерөнхий шаардлага MNS 4585: 2007 Агаарын чанарын стандарт MNS 4585:2016 Агаарын тоосжилтыг Dusttrak 8530 Шинжилгээний аргын стандарт, MNS 17.2.5.12:88 MNS 17.2.5.11:88 |
| 2 | Ус                       | Усны ерөнхий химийн шинжилгээ, (рН, ЕС, TDS, нийт шүлтлэг, хатуулгын хэмжээ, рН, цахилгаан дамжуулах чанар, Cl, SO <sub>4</sub> , NO <sub>2</sub> , NO <sub>3</sub> , CO <sub>3</sub> , HCO <sub>3</sub> ) | 8 сард                            | Гүний худаг  | Усны тухай хууль, Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус. Ерөнхий шаардлага MNS 4943:2008, Газрын доорх усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 6148:2010, Ундны усны, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900: 2005, Бохир ус 4943:2015,  |
| 3 | Хөрс                     | Хөрсний агрохими, нийт азот, хөдөлгөөнт фосфор, солилцох кали, карбонат, Хүнд металл (Cr, Pb, Cd, Ni, Zn), бактери   | 8 сард                            | Засварын талбай<br>Шимт хөрсний овоолго, кемп                        | - MNS3985-87 Хөрсний ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр, төрөл<br>- MNS3310-91 Хөрсний агро химийн үзүүлэлтийг тодорхойлох<br>- MNS2305-94 Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам<br>- MNS(ISO)4814:1999. Атом Шингээлтийн Спектрометрээр шинжилгээ хийх   |

2025 оны Орчны Хяналт Шинжилгээний ажлыг тус оны 8-р сард Байгаль орчны үнэлгээ, зөвлөгөөний “Ногоон Эко Мандала” ХХК хийж гүйцэтгэсэн.

Тус орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасны дагуу ус, хөрс, агаарын шинжилгээг хийлгэсэн.

**Агаар:**

Агаарын чанарын хэмжилт нь агаарын чанарын стандарт MNS 4585:2016-аас тоосны агууламж болон азот, хүхэрлэг хийн агууламжаар хэтэрсэн үзүүлэлт байхгүй.

**Ургамал:**

Цөлийн хээрийн үндсэн бүлгэмдэл болох баглуур-улаан бударганат бүлгэмдэлтэй. Гуу жалгаараа хармагт, бударганат зэрэг хагас сөөглөг ургамалын ургамалжилтай.

БОНХАЖЯ-ны 2015 оны 282 дугаар сайдын тушаалаар батлагдсан Ашигт ургамлын жагсаалтад ховор тархалтай 1 зүйл (*Zygophyllum potaninii*- потанини улаан тулам), элбэг тархалттай 7 зүйл (*Allium polyrrhizum*-таана, *Convolvulus ammonii*-Аммоний сэдэргэнэ, *Peganum nigellastrum*- өмхий өвс, *Rheum nanum*- намхан бажууна) ургамал ургана.

Бэлчээрийн талхагдал бага.

**Хөрс:**

Хөрсөн дээр хүнд металл илрээгүй. Цаашид засварын талбайг цементлэхийг зөвлөсөн. Бактериологийн шинжилгээгээр эмгэг төрөгч зүйл илрээгүй.

**Ус:**

Ундны усны химийн шинжилгээг “Ланп овнер” ХХК-ын лабораторид шилжүүлсэн. Ундны усны шинжилгээг тус талбайд ойролцоо байдаг малчны гар худгаас ундны усаа зөөврөөр хангадаг. Тус худгийн уснаас химийн шинжилгээ хийлгэсэн. Энэ худгийн ус нь химийн бүрэлдэхүүнээрээ хлорын ангийн, натрийн бүлгийн, 2-р төрлийн, чанарын хувьд цэнгэгдүү буюу харьцангуй ихэвтэр эрдэсжилттэй, хатуу ус байна.

ДУНДГОВЬ АЙМГИЙН ГУРВАНСАЙХАН СУМЫН НУТАГТ ОРШИХ МУ-022163 ТООТ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙ БҮХИЙ “МОРЪТ УУЛ”-ЫН ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН



Зураг 7. Уурхайн Орчны хяналт шинжилгээ хийж байх үед /2025.08.30/

**Хүснэгт 9. 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал**

| <b>Зардлын утга</b>  | <b>Нийт зардал, мян.төг</b> |
|--|-----------------------------|
| Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний ажлын зардал      | -                           |
| Газар болон хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний ажлын зардал | 17800.0                     |
| Ургамал болон амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах ажлын зардал              | 500.0                       |
| Хог хаягдлын менежментээр хийгдсэн ажлын зардал                                    | 1800.0                      |
| Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах ажлын зардал                        | 1462.9                      |
| Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ  | 5120.0                      |
| Тэр бум мод хөтөлбөр   | 1575.0                      |
| Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал                                       | 5000.0                      |
| Удирдлага зохион байгуулалтын ажлын зардал   | Дотоод зардал               |
| <b>2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардлын дүн</b>          | <b>33257.9</b>              |

## ДУГНЭЛТ

“Очир мандал хайрхан” ХХК-ийн “Морьт уул” хайлуур ордын талбай нь засаг захиргааны нэгжийн хувьд Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутагт байрладаг. Уурхайн ус ашиглах гэрээг 2025 оны 8-р сарын 18-ны өдөр байгуулсан гэрээний дагуу ажиллаж 1462.9 мян төгрөг зарцуулсан.

Газар эзэмших гэрээгээ өдөр байгуулж онд нийт 17800.0 мян.төг төлсөн.

Техникийн болон Биологийн нөхөн сэргээлт 2025 онд төлөвлөөгүй бөгөөд шимт хөрс хадгалж хамгаалах ажил хийгдсэн.

2025 оны 4-р сард Их газрын чулуу байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаатай хийсэн хамтын ажиллагааны гэрээний дагуу биотехникийн арга хэмжээ авах ажилд хамтран ажиллав.

Гурвансайхан сумын нутагт зүүн урд хэсэгт байрлах сумын цэцэрлэгт хүрээлэнд мод тарих ажилд хамтран ажилласан бөгөөд 300 м хамгаалалтын тор, 100ш мод тарималжуулав

2025 оны Орчны Хяналт Шинжилгээний ажлыг тус оны 8-р сард Байгаль орчны нарийвчилсан үнэлгээний эрх бүхий “Ногоон Эко Мандала” ХХК-аар хийж гүйцэтгүүлсэн. Тус орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасны дагуу ус, агаарын тоосжилт, хөрс, усны шинжилгээ хийсэн.

2025 оны 11-р сарын байдлаар байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийт 33.2 сая төгрөг зарцуулсан байна.



Огноо/Date: 2025-04-30 17:52:49

Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information

Журналын /Journal No: 47392883

Гүйлгээний дугаар /PoId: 0

Системийн огноо/System Date: 2025-04-30 17:44:10

| Дт | IBAN/Дансны/Картын дугаар<br>IBAN/Account/Card number | Нэр/Name                           | Дүн/Amount       |     | Ханш/Rate |
|----|---|------------------------------------|------------------|-----|-----------|
|    | 5466120492  | ОЧИР МАНДАЛ ХАЙРХАН                | 5,757,500.00     | MNT | 1.00      |
| Кт | Банкны дугаар/Branch No<br>MOFUMNUB                   | Банкны нэр/Bank Name<br>ТӨРИЙН САН | 5,757,500.00 MNT |     | 1.00      |
|    | IBAN/Дансны/Картын дугаар<br>IBAN/Account/Card Number | Нэр/Name                           |                  |     |           |
|    | MN190090 000900013406                                 |                                    |                  |     |           |

Гүйлгээний утга/Transaction description:

ЕВ-MV-22163 2025 ОНЫ БОМТ-НИЙ БАРЬЦАА ХӨРӨНГӨ

Харилцагч танд баярлалаа./Thank you to our customers

Гүйлгээний баримтыг баталгаажуулсан/Transaction statement verified:

Салбар, тооцооны төв/Branch, sub-branch:

Гарын үсэг/Signature:

Тамга/Stamp:

\_\_\_\_\_ Он/Year (YYYY) \_\_\_\_\_ Сар/Month (MM) \_\_\_\_\_ Өдөр/Day (DD)

БАТЛАВ  
ГУРВАНСАЙХАН СУМЫН ЗАСАГ  
ДАРГА  Б.ЭНХТУЯА

ХОГ ХАЯГДЛЫН ГЭРЭЭ

2025.08.03

Суугаант

№ 08

**Нэг. Ерөнхий зүйл**

- 1.1 Энэхүү гэрээний гол зорилго нь Гурвансайхан сумын нутаг дэвсгэр дэхь уул уурхайн ААНБ, Албан газар, Айл өрхийн хог хаягдлыг эмх цэгцтэй байлгах, хууль дүрэмийг мөрдүүлэх, хогийн менежментийг сайжруулах үүнтэй холбогдон гарсан төлбөр тооцооны харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Нэг талаас БО мэргэжилтэн Г.Алтангэрэл, Нөгөө талаас 3435474 тоот регистрийн дугаартай “Очир мандал хайрхан” ХХК –ийн Захирал Б. Батбаяр нар уурхайн талбайд хуримтлагдсан хог хаягдлыг өөрийн техик хэрэгсэлээр сумын төвийн нэгдсэн цэгт төвлөрүүлэх, хог хаягдлын талбөр хураамжийг тогтсон хугацаанд ОН төсөвт төвлөрүүлэхээр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.
- 1.3 Энэхүү гэрээг 2025 оны 06 сарын 01 –ний өдрөөс 2025 оны 12 сарын 31-ны өдөр хүртэл хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 1.4 Дундговь аймгийн Гурвансайхан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын **2019 оны 11 сарын 15-ны өдрийн 36 дугаар** тогтоолоор баталсан үнийн тарифыг дагаж мөрдөнө.
- 1.5 Гэрээний хугацаа дуусаас нэг сарын өмнө талууд гэрээ цуцлах санал гаргаагүй бол гэрээг дахин 1 жилээр сунгасанд тооцно.

**Хоёр. А талын эрх үүрэг.**

- 2.1 Захиалагч нь гарсан хог хаягдлыг тогтсон хуваарийн дагуу тээвэрлэн сумын төвийн төвлөрсөн хогийн цэгт саадгүй буулгах эрхтэй.
- 2.2 Захиалагч нь ямарч тохиолдолд гарсан хог хаягдлыг зориулалтын бус газарт ил задгай хаяхыг хориглоно.
- 2.3 Захиалагч нь гарсан хог хаягдлыг зориулалтын уутанд хийж хогийн цэг, бункерт түр хадгалах үүрэгтэй.

- 2.4 Захиалагч нь гарсан хог хаягдлын төлбөрөө тогтоосон тарифын дагуу цаг хугацаанд төлж байх үүрэгтэй.
- 2.5 Тухайн ААН, байгууллага өөрийн талбай /хашаа/-аас гадагш **100 метр** зай дахь талбайн цэвэрлэгээг хариуцах үүрэгтэй. Цас орж, мөс тогтсон бусад байдлаар бохирдсон тохиолдолд тухайн талбайн цэвэрлэгээг тогтмол хийж ойр орчмын цэвэр байдлыг ханган ажиллах үүрэгтэй.
- 2.6 Хог агуулах зориулалтын савыг өөрийн хөрөнгөөр шийдвэрлэх бөгөөд хог ачихад саад учруулахгүй газар байрлуулж машин чөлөөтэй орж гарах нөхцөлийг бүрдүүлнэ. Олон улсын стандартын дагуу гаргасан загвар, хэмжээний дагуу хог агуулах савыг хийх.
- 2.7 Захиалагч нь хийсэх болон бусад хог хаягдлыг заавал уутанд хийж байх.
- 2.8 Аюултай хог хаягдлыг стандартын дагуу, зориулалтын саванд хадгалан, мэргэжлийн байгууллагаар тээвэрлүүж байх үүрэгтэй.
- 2.9 Аюултай хог хаягдлын журнал дэвтэр хөтлөх үүрэгтэй.
- 2.10 Орон нутгаас зохион байгуулсан бүх нийтийн цэвэрлэгээний ажилд идэвхитэй оролцох үүрэгтэй.

#### **Гурав. Б талын эрх үүрэг**

- 3.1 Гүйцэтгэгч нь гарсан хог хаягдлыг заасан хуваарийн дагуу заасан хугацаанд саадгүй ачиж тээвэрлүүлэх үүрэгтэй.
- 3.2 Гүйцэтгэгч нь төлбөрийг нэхэмжлэх заасан хугацаандаа төлөхийг шаардах эрхтэй.
- 3.3 Захиалагч тогтоосон хугацаанд төлбөрөө барагдуулагүй тохиолдолд хог хаягдлыг тухай хуулиар арга хэмжээ авч ажиллах эрхтэй.
- 3.4 Уул уурхай, барилгын болон уурын зуухны үнс, нүүрсний хог хаягдлыг тусгай үнэ тарифаар тооцно.

#### **Дөрөв. Төлбөр тооцоо, үнэлгээ**

- 4.1 Дундговь аймгийн Гурвансайхан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2019 оны 11 сарын 15-ны өдрийн 36 дугаар тогтоолоор баталсан үнийн тарифыг дагаж мөрдөнө.
- 4.2 Захиалагч нь хог хаягдал гаргасаны төлбөр хураамжийг 1 сард 300.000 төлбөрийн дүнг /гурван зуун мянга/-н мянган төгрөг “Очир мандал хайрхан” ХХК- ийн

Нийт төлбөр:, 1.800,000 төгрөг 1 сарын төлбөр 300.000 төгрөгөөр

тооцон сар бүрийн 25-ны дотор **Гурвансайхан сумын татварын орлогын 100080700947** дансанд шилжүүлнэ.

- 4.3 Захиалагч нь төлбөр тооцоог улирал, хагас жил, жилээр нь төлж болно.

4.4 Хог хаягдлын хураамжийг хугацаа хожимдулсан тохиолдолд хоног тутамд 0,5%-ийн алданги нэмж төлнө.

**Тав. Хамтран хүлээх хариуцлага**

5.1 Талууд энэхүү гэрээ зөрчигдөөгүй тохиолдолд дангаараа гэрээг цуцлах эрхгүй.

5.2 Талууд аливаа маргаан, үл ойлголцлыг харилцан тохиролцож шийдвэрлэх бөгөөд шаардлагатай тохиолдолд хуулийн байгууллагад хандаж шийдвэрлүүлнэ.

**Зургаа. Бусад**

6.1 Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга дарснаар хүчин төгөлдөр болно.

6.2 Гэрээнд тусгагдаагүй боловч нэмж оруулах, гэрээнд өөрчлөлт хийх шаардлагатай тохиолдолд талууд харилцан тохиролцож шийдвэрлэнэ. 20... оны ... сарын ....-ний өдөр талууд харилцан тохиролцож энэхүү гэрээнд дараах нэмэлт өөрчлөлтийг оруулав.

.....  
.....  
.....

**Долоо. Гэрээний сунгалт**

7.1 Гэрээний хугацаа дуусаж, талууд гэрээг цуцлах талаар албан бичгээр санал гаргаагүй бол гэрээг анх байгуулагдсан хугацаагаар сунгагдсанд тооцно.

7.2 Энэхүү гэрээг 20... оны .... сарын .... өдрөөс 20... оны .... сарын .... өдөр хүртэл талууд харилцан тохиролцож сунгалт хийсэн болно.

Гэрээ сунгасан: \_\_\_\_\_

Гэрээ сунгасан: \_\_\_\_\_

сунгав

Гэрээ байгуулсан:

Гүйцэтгэгчийг төлөөлж  
Байгаль орчны мэргэжилтэн  
...../Г.Алтангэрэл/  
Утас: 99977590

Захиалагчийг төлөөлж  
“Очир мандал хайрхан” ХХК  
Уурхан дарга .....  
Э.Мөнх-Эрдэнэ  
Утас: 95347341

БАТЛАВ.  
ОЧИР МАНДАЛ ХАЙРХАН ХХК-НИЙ  
ЗАХИРАЛ: *Батбаяр* БАТБАЯР

БАТЛАВ.  
ГУРВАНСАЙХАН СУМЫН ЗАСАГ  
ДАРГА: *Б.Энхтуяа* Б.ЭНХТУЯА

### УС АШИГЛУУЛАХ ГЭРЭЭ

2025.08.18

Дугаар 10

Суугаант

#### Нэг. Ерөнхий зүйл

Усны тухай хуулийн 28.4, 28.6, 28.7, 29.1-д заасны дагуу Дундговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2025 оны 07 сарын 29 –ний Е-2506-000164 дугаар ус ашиглуулах дүгнэлт үндэслэн:

Ус ашиглуулагчийг төлөөлж Дундговь аймгийн Гурвансайхан сум ЗДТГ-ын БО мэргэжилтэн Гансүх овогтой Алтангэрэл

Ус ашиглагчийг төлөөлж “Очир мандал хайрхан” -тай ХХК-ний Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутаг дэвсгэрт ашигт малтмалын, ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй улсын бүртгэлийн №811001097, регистрийн № 3435474 “Очир мандал хайрхан” ХХК-ний Уурхайн дарга Э.Мөнх-Эрдэнэ нар ус ашиглах талаар тохиролцон энэхүү гэрээг 1 жилийн хугацаатайгаар байгуулав.

#### Хоёр. Гэрээний гол нөхцөл

Ус ашиглах зориулалт: Дулаан эрчим хүч үйлдвэрлэх, түгээх, зхицуулалттай хангах.

Ашиглах усны хэмжээ:

- |      |                              |                              |
|------|------------------------------|------------------------------|
